



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/72

Есөнбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Есөнбулаг сумын иргэн Я.Нарангэрэлд орон сууцны дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

